



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/600

Хэрлэн сум

“Бидний бахархал” төслийн арга хэмжээг
зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.13, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Монгол цэргийн нэгдсэн холбоо”-оос зохион байгуулж буй хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий “Бидний бахархал төсөл”-ийн үйл ажиллагааг 2022 оны 11 дүгээр сарын 29-д Хэрлэн сум, 2022 оны 11 дүгээр сарын 30-д Бэрх тосгон, 2022 оны 12 дугаар сарын 02-д Дэлгэрхаан суманд тус тус зохион байгуулсугай.

2. “Бидний бахархал төсөл”-ийн үйл ажиллагааг зохион байгуулахад Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбарт дэмжлэг үзүүлж, 1,800,000 (нэг сая найман зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй, урьдчилан төлөвлөх боломжгүй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д зөвшөөрсүгэй.

3. “Бидний бахархал төсөл”-ийн үйл ажиллагааны бэлтгэлийг сайтар хангуулан зохион байгуулж ажиллахыг Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбарын Нарийн бичгийн дарга (Ц.Батсайхан)-д, мэргэжлийн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Цэргийн штабын дарга (хурандаа Н.Хүрэлээ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ